

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: **Принтерийн хор нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХАН№20/18**

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг,
үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС”
ТӨХК-ийн конторын байр.

Утас: 99020551, 99665151
Факс: 70210167

БЗӨБЦТС ТӨХК 2020 он.

Нэг. ХА№20/18 дугаартай Принтерийн хор нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга

БЗӨБЦТС ТӨХК нь **Принтерийн хор** нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Утас: 99665151, 99020551

Факс: 70210167

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ. 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон ийлүүлэлтийн хуваарь; (в) Техникийн тодорхойлолт. (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/ |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|---|
| ТӨӨЗ 1.1 | <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналын маягтын дагуу үнийн санал ирүүлнэ. 2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар. НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ. 3. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /Цахим тендерийн системээс татагдсан татварын тодорхойлолтыг үндэслэнэ/ 4. 2019 оны нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 5. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт, зураг ирүүлнэ. /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан байх/ 6. Тендерт оролцогч принтерийн хор худалдан борлуулдаг цэг болон принтерийн хорыг стандартын дагуу хадгалах агуулахтай байна. /Нотлох баримтыг зургийн хамт ирүүлнэ/. 7. Санал болгож байгаа принтерийн хор нь олон улсын ISO14001:2015, ISO9001:2015 чанарын стандартыг хангасан байх шаардлагатай. /Нотариатаар баталгаажуулсан нотлох баримтыг орчуулгын хамт ирүүлнэ/ 8. Үйлдвэрлэгч, дистрибьютер, албан ёсны гэрээт борлуулагчийн аль нэгээр ажилладгийг нотлох баримт бичиг, үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, үйлдвэрлэгч улсын чанарын шаардлага хангаж байгааг нотлох баримт, үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээний хуулбар, гэрчилгээ ирүүлнэ. /Нотлох баримтыг орчуулгын хамт ирүүлнэ. Үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээг нотариатаар баталгаажуулсан байна/ 9. Гэрээний тусгай нөхцлийн 4 дүгээр заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 10. Баталгаат засварын хугацааг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. /Баталгаат засварын хугацаанд гарсан эвдрэл гэмтэлтэй принтерийн хорыг 3 /гурав/ хоногийн дотор шуурхай сольж өгнө гэсэн ГТН 3-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ/ 11. Бараа материал нийлүүлэх хугацаа хуанлийн 10 хоногоос ихгүй байна. 12. Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлага |
| ТӨӨЗ 2.1 | <p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах цахим хаяг, утасны дугаар: И-мэйл: И-мэйл: webmail.bnedo.mn Утас: 99665151</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 цаг 00 минут.</p> |
| ТӨӨЗ 2.2 | <p>Тендерийн нээлт хийх хугацаа нь: Цахим тендерийн нээлтийг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 цаг 30 минутад цахим системээр нээнэ.</p> |

| | |
|-----------------|--|
| ТӨӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендергээ нууцлалгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн аж ахуйн нэгж сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчөөгүй тухай шүүхийн тамгын газрын тодорхойлолт. 2. Тухайн аж ахуйн нэгж сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэг болон авилгалын гэмт хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт. 3. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт. /Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх/ 4. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p> |
| ТӨӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй |

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Барааны тодорхойлолт:

2. **Стандарт:** ISO14001:2015, ISO9001:2015 болон үйлдвэрлэгч улсын чанарын стандартыг хангасан байх шаардлагатай.

3. **Бараа хүргэх газар:** Багануур дүүрэг, БЗӨБЦТС ТӨХК-ийн байранд.

4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмж их нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|----------------|--------------|------------|--------------|--|---|--------------------------|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Принтерийн хор | | | | Багануур дүүрэг, БЗӨБЦТС ТӨХК-ийн байранд. | 7 хоног | 10 хоног | |
| | | | | | | | |

Бараа материалын тоо хэмжээ, нэр төрөл

| № | Принтерийн хорны нэр төрөл | Принтерийн нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|----|--|--|-------------|------------|
| 1 | Принтерийн хор-12 А | Принтерийн хор-12 А /HP LaserJet P1018, Canon L11121e/ | ш | 46 |
| 2 | Принтерийн хор-17А | HP LaserJet Pro MFP M130 fn | ш | 5 |
| 3 | Принтерийн хор-35А | HP LaserJet P1102, HP LaserJet P1005 | ш | 168 |
| 4 | Принтерийн хор-78А | HP LaserJet MFP 1536 dnf | ш | 11 |
| 5 | Принтерийн хор-85 А, 285А | HP LaserJet 1102, HP LaserJet P1005, LaserJet M1132, LaserJet M1212, Canon LBP6018 | ш | 188 |
| 6 | Принтерийн хор-83 А | Canon MF22bdn, LaserJet M125 | ш | 38 |
| 7 | Принтерийн хор 87А, 287А | HP LaserJet M506 dn | ш | 48 |
| 8 | Принтерийн хор 101S | Samsung ML2165, Samsung M2070 | ш | 68 |
| 9 | Принтерийн хор 111S | Samsung Xpress M2020, M2070, Samsung SCX 2020/2070 | ш | 55 |
| 10 | Принтерийн хор D115L | Samsung Xpress M2870FD | ш | 16 |
| 11 | Принтерийн хор D105S | Samsung SCX-4623F | ш | 6 |
| 12 | Кюсера 2552А лазер принтерийн өнгөт хор /оригинал/ | Kyocera TASKalfa 2552ci | ком | 1 |
| 13 | Принтерийн өнгөт хор /6 өнгөтэй баллонтой/ | Epson T-50 | ш | 10 |
| 14 | Принтерийн хор өнгөт /6 өнгөтэй баллонтой/ | Epson 290 | ш | 24 |
| 15 | Принтерийн өнгөт хор /4 өнгөтэй/ | Epson L360 | ш | 21 |
| 16 | Принтерийн өнгөт хор /4 өнгөтэй/ /оригинал/ | HP OfficeJet 7500 A | ком | 3 |
| 17 | Принтерийн хор өнгөт /6 өнгөтэй/ | Epson XP442 | ш | 6 |
| 18 | Принтерийн хор өнгөт /6 өнгөтэй баллонтой/ | Epson Styles Photo 1390 | ш | 19 |
| 19 | Принтерийн хор өнгөт / баллонтой/ | Epson Styles Photo 230 | ш | 30 |
| 20 | Принтерийн хор өнгөт /4 өнгөтэй/ /оригинал/ | Epson WorkForce WF-7721 | ш | 12 |
| 21 | Хорны картриж | Epson Styles Photo 1390 | ш | 1 |

Жич: 12А, 17А, 78А, 83А, 85А, D101S, 111S принтерийн хорнуудын дээжийг тендерийн нээлтээс өмнө БЗӨБЦТС ТӨХК-ийн байранд ирүүлнэ.

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2020 оны дүгээр сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлнэ. Үүнд: Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, гэрээний үүргээ бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 /нэг/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан төлнө. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Захиалагч бараа материалыг ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн бараа материалыг хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- 1) **Баталгаат засварын хугацаа 1 жил байна.**
 - 2) **Баталгаат засварын хугацаанд гарсан эвдрэл гэмтэлтэй принтерийн хорыг 3 хоногийн дотор шуурхай сольж өгнө.**
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Барааг бүрэн хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гэрээний үнийн дүнгийн **100 хувийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан** төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн **0,5%**.
- Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-с** ихгүй байна.